

"ХӨДӨӨ ОРОН НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛД ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ ОРОЛЦООГ ХАНГАХ НЬ" БҮЮУ ИМПАКТ ТӨСӨЛ



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Орон нутгийн иргэд газар тариалан, мал аж ахуйгаас орлогын эх үүсвэрээ хангахын зэрэгцээ өрхийн үйлдвэрлэлийн арга барилаа орчин үеийн нөхцөл байдал, хандлагад тохируулан боловсронгуй болгох шаардлагатай байна.

Мал маллах, тариалан болон бусад аж ахуй эрхэлж, өрхийн үйлдвэрлэлээ хөгжүүлж, орлогоо нэмэгдүүлэхэд эмэгтэйчүүдийн оролцоо, шийдвэр их үүрэгтэй байдаг. Иймд орон нутгийн түвшинд эмэгтэйчүүдийг чадваржуулах, манлайллыг дэмжих бодлого баримталж, байгаль орчин, эдийн засгийн өнөөгийн сорилтуудыг даван туулах, дасан зохицох, улмаар орон нутгийн хөгжил, өнөө болон хойч үеийнхний сайн сайхан байдалд хувь нэмэр оруулах хүсэл, эрмэлзлийг нь дэмжих нь чухал юм.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Орон нутгийн түвшинд шийдвэр гаргах үйл явцад эмэгтэйчүүдийн манлайлал, оролцоог нэмэгдүүлэх замаар тогтвортой ноолуур, органик ногооны үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ГАЗРУУД

Архангай аймаг



Хэнтий аймаг



 Хүнсний ногоо  Тогтвортой ноолуур

ТӨСЛИЙН САНХҮҮЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД:



Монгол Улсын

Малчдын

45%

ЭМЭГТЭЙЧҮҮД

Тариаланчдын

75%

ТӨСЛИЙН ЗОРИЛТОТ БҮЛГҮҮД

Шууд:

1700 өрх



30

эмэгтэйчүүдийн
бүлэг, иргэний
нийгмийн
байгууллага



2 аймгийн
6 сумын удирдлага



Шууд бус:

Зорилтот 2 аймгийн
эмэгтэйчүүдийн
50% буюу
50,000 хүн

50%

ТӨСЛИЙН ЗОРИЛТУУД:

ИМПАКТ төсөл нь эрчим хүчний хэмнэлттэй шийдлүүдийг нэвтрүүлж, тогтвортой ноолуур, органик ногоо тариалалтын сайн туршлагуудыг бий болгох замаар үйлдвэрлэгч эмэгтэйчүүдийг чадваржуулж, шийдвэр гаргах үйл явцад оролцдог, орон нутгийнхаа эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулдаг болоход нь дэмжлэг үзүүлэх юм. Төсөл нь орон нутгийн эдийн засгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор иргэдийн эрх тэгш оролцоог хангасан дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:



Бүтээгдэхвэн үйлдвэрлэж буй эмэгтэйчүүдийг чадваржуулах



Органик хүнсний ногоо, тогтвортой ноолуур үйлдвэрлэлийн нэмүү өртгийг бич болгох



Эмэгтэйчүүд үндэсний болон орон нутгийн удирдлагатай хэлэлцэх, шийдвэрт оролцохыг дэмжих



Жендерийн мэдрэмжтэй эдийн засгийн хөгжлийн загваруудыг сурталчилах

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД:



AVSF Монгол

Малын гаралтай түүхий эдийн тогтвортой үйлдвэрлэл, нэмүү өртгийн сүлжээг сайжруулах, малчдын амьжиргааг дэмжих чиглэлд үйл ажиллагаа хэрэгжүүлдэг



ЖЭРЭС

Жэрэс нь Европ, Африк, Ази тивд 40 гаруй жил ажиллаж буй эрчим хүч, тогтвортой хөгжлийн чиглэлээр мэргэшсэн олон улсын ТББ бөгөөд ард иргэдийн амьдрах нөхцөлийг сайжруулахад хувь нэмрээ оруулах замаар уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах үйл ажиллагаа явуулдаг.



МОНЭС

Монголын Эмэгтэйчүүдийн Сан 2000 оноос Монгол эмэгтэйчүүдийн хөгжил дэвшлийн төлөө, тэдний хvний эрхийг хамгаалах чиглэлээр гаргаж буй идэвхи санаачлагыг дэмжин ажилладаг.



ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР НӨЛӨӨ:



Өрхийн орлого нэмэгдэж, амьдралын чанар сайжирна

Орон нутагт эдийн засгийн үйл ажиллагаа төрөлжинө

Хөрөнгө санхүүгээ удирдах эмэгтэйчүүдийн хувь, оролцоо нэмэгдэнэ

Үйлдвэрлэл эрхлэх, шийдвэр гаргахад эмэгтэйчүүдийн үүрэг оролцоог үнэлдэг болно

Жендерийн эрх тэгш байдлыг дэмжсэн эдийн засгийн хөгжлийн бодлого бий болно



Тогтвортой ноолуур, органик хүнсний ногооны нэмүү өртгийн сүлжээ бий болно

Бэлчээрийн хамтын менежмент, тогтвортой ноолуур бэлтгэлийг дагаад бэлчээрийн доройтлыг бууруулах нөхцөл бүрдэнэ

Орон нутагт органик хүнсний ногооны хангамж нэмэгдэж, хүнсний аюулгүй байдал сайжирна

Хүнсний ногоо тариалах, хадгалах эрчим хүчний хэмнэлттэй шийдлүүд нэвтрүүлнэ

Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 3 дугаар баг,
Ар арвижин дэлгэрэх хоршооны байр
Утас: +976-88096422

Холбоо барих

Хэнтий аймаг, Хэрлэн сум, 4-р баг,
ЗДТГ-ын байр, 201 тоот,
Утас: +976-91114758